



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 17 едөр

Дугаар 8/99

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах өрөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах өрөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эзэн Төр ХХК-ийн "Мөрөн" зочид буудлын 13/92, Бодь Мөр Интернэшнл ХХК-ийн "Ниппон" зочид буудлын 15/045, Их Алтай ХХК-ийн "Хан" дэн буудлын 15/103, Иргэн П.Рэгзэдмаагийн "Од Намуун" дэн буудлын 15/015 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 11 сарын 17 өдрийн
А/99 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

УОА0453

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХҮЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.11.17

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------------------------|-------------|--|
| 1 | Эзэн төр ХХК | 2034654 | Мөрөн | Баянгол дүүрэг, 8-р хороо, Дилавхутагт Жамсранжавын гудамж 1 |
| 2 | Бодь Мөр Интернэшнл ХХК | 2622912 | Ниппон | Баянгол дүүрэг, 4-р хороо, Нарны зам 1/196 |

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 11 сарын 17 өдрийн
А/99 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.11.17

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------------------------|-------------|---|
| 1 | Цэрэнхишиг ХХК | 2884151 | Оргилуун | Сүхбаатар дүүрэг, 14-р хороо, Хандгайтын 30/376 |
| 2 | Их Алтай ХХК | 2565595 | Хан | Баянгол дүүрэг, 9-р хороо, Хасбаатарын гудамж |
| 3 | Иргэн Д.Цэээн | ЧК62021600 | Намуун | Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, 48-р байр |

-ооОоо-